Халдварт бус өвчний хэвлэмэл материалд хийсэн үнэлгээ

О.Булган[1], Л.Баярмагнай[1], С.Балжиннямм[2], Б.Чимгээ[3], Т.Энхтуяа[4], Ч.Өнөрцэцэг[1], Ө.Гандолгор[1], Д.Хишигтогтох[1]
[1]АШУҮИС. Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
[2]ЦТЭ. Мэс заслын клиник
[3]Хэнтий НЭ. Төрөх тасаг
[4]Ховд аймаг. Буянт сумын ЭМТ

Үндэслэл: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын мэдээгээр халдварт бус өвчин дэлхийн хүн амын нийт өвчлөлийн 43%, нас баралтын шалтгааны 73%-ийг эзлэн, цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. ДЭМБ-ын судалгаагаар Монгол улс бага болон дунд орлоготой орнуудын дунд ХБӨ-ний тархалт өндөртэй хоёр дахь орон болж байна. Үндэсний хэмжээнд хийгдсэн ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаагаар (2005, 2009, 2013) өвчлөл 18-64 насны хүн амын дунд төдийлөн буурахгүй байна. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолоор "Халдварт бус өвчинтэй тэмцэх" үндэсний хөтөлбөрийг баталж, ХБӨ-ний эрт илрүүлгийн хамрагдалтыг зонхилон тохиолдож буй өвчлөл бүрд бууруулахаар зорьж байна. Тухайлбал, 2021 он гэхэд умайн хүзүүний хорт хавдрыг (30-60 нас) 51.9 хувь, хөхний хорт хавдрыг (30-60 нас) 307921, цусны даралт ихсэх өвчин (40-64 нас) 79.5 хувь, чихрийн шижин (40-64 нас)-гийн илрүүлгийг 77.5 хувьд хүргэх зорилтуудыг дэвшүүлээд байна.
Зорилго: Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ӨЭМТ-үүдэд явуулж буй мэдээлэл харилцааны үйл ажиллагаанд үнэлгээ өгч, тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг судлах зорилго тавьсан юм.
Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгаанд нийслэлийн 8 дүүрэг, 4 аймгийн 63 өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй зорилтот бүлгийн иргэд, сонгогдсон өрхийн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Судалгааны мэдээ материал цуглуулахдаа шалгах хуудас ашигласан. Хэвлэмэл материалд тавигдах үндсэн шалгууруудын дагуу ӨЭМТ-ийн боловсруулан гаргаж буй материалд багийн гишүүдийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийн, харьцуулсан болно.
Үр дүн: Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс ХБӨ-ний чиглэлээр боловсруулан гаргаж буй материалуудын үйлчлүүлэгчийн анхаарал татахуйц байдлыг иргэдийн 38.6% хангалттай сайн, 35% нь дунд, 26.4% хангалтгүй гэж үнэлсэн бол эмнэлгийн ажилчдын өөрсдийн үнэлгээгээр тухайн үзүүлэлтэнд 62.6% нь хангалттай, 29.4% нь дунд, 8% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Харин хөндлөнгийн үнэлгээгээр дээрхи үзүүлэлт хангалттай 19.3%, дунд 28.1%, хангалтгүй 52.6% үнэлгээтэй байлаа. Өгч буй мэдээллийн ойлгомжтой байдлыг 48.8% нь хангалттай, 32.7% нь дунд, 18.5% нь хангалтгүй, харин эмнэлгийн мэргэжилтнүүдийн дийлэнх буюу 82.4% нь өөрсдийн боловсруулсан мэдээллийг хангалттай сайн агуулгатай, ойлгомжтой бэлтгэсэн гэж үзсэн байна. Гэвч тухайн үзүүлэлтийн хувьд хөндлөнгийн үнэлгээний дүн үйлчлүүлэгчийн үнэлгээтэй ойролцоо буюу 45.6% нь хангалттай сайн, 40.4% нь дунд, 14% нь хангалтгүй үнэлгээтэй байна. Үйлчлүүлэгдийн хувьд эрүүл мэндийн талаар авсан мэдээллээ ойлгох байдалд хүйсийн ялгаатай байдал харагдаж байсан ба эмэгтэйчүүдийн 54.7% нь, эрэгтэйчүүдийн 39.8% нь хангалттай ойлголт авсан гэж үзсэн байна. Хэвлэмэл материалын зураг, дүрслэл, өнгөний хоршлыг орон нутгийн үйлчлүүлэгчдийн 5 хүн тутмын нэг нь, харин нийслэлийн иргэдийн 2 хүн тутмын нэг нь зохимжтой, хангалттай сайн гэж үнэлсэн. Түүнчлэн хэвлэмэл материал дахь мэдээллийн зөв бичгийн дүрэм баримтлах, найруулга, үг үсгийн алдаагүй бичигдсэн байдлыг нийслэлийн иргэдийн 69.1% нь, орон нутгийн иргэдийн 36% нь сайтар хянаж, хангалттай сайн боловсруулсан байна гэж дүгнэсэн. Тухайн хэвлэмэл материал дахь ХБӨ-ний талаар өгсөн зөвлөгөөг бодит амьдрал дээр мөрдөх, хэрэгжүүлж ажиллах боломжийн хувьд эмэгтэйчүүдийн 48.3% нь хангалттай сайн, 30.6% дунд, харин эрэгтэйчүүдийн хувьд 38.9% нь хангалттай, 34% нь дунд гэж үнэлсэн нь амьдралд ойрхон, хэрэгжүүлэх боломжтой талаас нь өгч буй мэдээллийг боловсруулж байгаа нь харагдаж байна. ӨЭМТ-үүд дэх хэвлэмэл материалыг боловсруулан гаргасан эх сурвалжийг нь авч үзвэл ӨЭМТ-үүдийн эмч мэргэжилтэнүүд өөрсдийн зүгээс бэлтгэсэн нь 21%, НЭМҮТ, ЭМЯ, ДЭМТ-үүдээс бэлтгэн гаргасан хэвлэмэл материал 50.8%, эмийн компанийн хэвлэмэл материал 75.4% тус тус байлаа.
Дүгнэлт:
1. ӨЭМТ-үүдээс боловсруулан гаргаж буй эрүүл мэндийн талаарх хэвлэмэл материал нь зорилтот бүлэгтээ тодорхой хэмжээнд хүрч, тэдний анхаарлыг татаж чадаж байна. Тухайлбал үйлчлүүлэгчдийн 73.6% нь дундаас дээш үнэлгээтэй байна. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн өөрсдийн үнэлгээгээр 92% нь дунджаас дээш гэж үнэлсэн нь төвүүд үйл ажиллагаандаа бодитоор хандан, цаашдын мэдээлэл боловсруулах ажилдаа хөндлөнгийн үнэлгээ, ялангуяа зорилтот бүлгийн санааг тусган маркетингийн стратегийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
2. Зөвхөн хэвлэмэл материалын өнгө үзэмж төдийгүй, доторх мэдээллийн агуулга, бичвэрийн найруулга, зөв бичгийн дүрэм, үг үсгийн алдааг нарийн сайн хянаж хэвлэх нь чухал байна. Энэ үзүүлэлт орон нутгийн хэвлэмэл материалд илүүтэй харагдаж байсан буюу нийслэлийн хэвлэмэл материалын 30.9% нь, орон нутгийн 64% нь алдаа ихтэй хэвлэгдсэн байна.
3. Хэвлэмэл материал дахь мэдээлэл, зөвлөгөөний ойлгомжтой байдал харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн мэдээлэл авах, түүнийг тусган ойлгох байдал хүйсийн хувьд ялгаатай буюу эрэгтэйчүүдийн хувьд дутмаг байдал анзаарагдаж байна. Иймд эрүүл мэндийн мэдээлэл, харилцааны ажилд зорилтот бүлгийг нарийн сегментчилж, мэдээллээ боловсруулах шаардлага тулгарч байгаа юм.
4. Иргэдэд зориулсан эрүүл мэндийн мэдээлэл өгөх хэвлэмэл материалыг ӨЭМТ-үүд өөрсдийн зүгээс хэвлэн бэлтгэх нь бага буюу дийлэнх ӨЭМТ-үүд нь эмийн компани, ЭМЯ, НЭМҮТ, ДЭМТ-үүдээс бэлтгэсэн материалыг ашиглаж байна.

Assessment on print media about non-communicable disease

Bulgan O[1], Bayarmagnai L[1], Baljinnyam S[2], Chimgee B[3], Enkhtuya T[4], Unurtsetseg Ch[1], Gandolgor O[1], Khishigtogtokh D[1]

[1]MNUMS. School of Public Health
[2]CMH. Surgical clinic
[3]United hospital of Khentii province. Maternity department
[4]Khovd province. Central hospital of soum Buyant

Introduction: As claimed by the World Health Organization (WHO), non-communicable diseases (NCD) account for 43% of total morbidities, responsible for about 73% of all deaths and these statistics are expected to increase further. According to the research made by the WHO, Mongolia is considered as the second country with the high prevalence of NCDs among low- and middle-income countries. A nationwide hierarchical study on the prevalence of NCD risk factors (2005, 2009, 2013) did not show significant decrease in morbidity of the population aged between 18 and 64. In 2017, the Government of Mongolia approved resolution numbered 289, "National program to prevent non-communicable diseases", and continuously working to decrease the number of cases for the most common NCDs. For instance, the program objectives include decreasing cases of cervical cancer to 51.9%, breast cancer to 307,921 cases for the population aged between 30 and 60, and hypertension to 79.5% and diabetes mellitus to 77.5% for the population aged between 40 and 64 by 2021.

Purpose: To assess health information and communication activities being promoted at Basic Health Units (BHU) to increase the attendance for early detection of the most common NCDs and identify the problems that BHUs are facing.

Materials and methods: We involved targeted individuals, doctors and medicals specialists of 63 BHUs of 4 provinces of Mongolia and 8 districts of capital city, Ulaanbaatar, in the research. We used score sheet to collect materials and data for the research. According to basic requirements of print media, we made self and independent assessment on materials prepared by BHUs and compared the results.

Results: As for the attractiveness of materials about NCDs, which are being produced by BHUs, 38.6% of individuals evaluated them as "excellent", 35% as "satisfactory" and 26.4% as "poor" while 62.6% of doctors and medical specialists answered "excellent", 29.4% as "satisfactory" and 8% as "poor". However, 19.3% of materials were evaluated as "excellent", 28.1% as "satisfactory" and 52.6% as "poor" by independent evaluators. With regards the comprehensibility of information, 48.8% of individuals evaluated them as "excellent", 32.7% as "satisfactory" and 18.5% as "poor" while 82.4% of doctors and medical specialists think these materials prepared by them included sufficient information and easy to understand. Nonetheless, 45.6% of independent evaluators think the comprehensibility of information as "excellent", 40.4% as "satisfactory" and 14% as "poor" which is similar as the result of individuals' assessment. Moreover, gender difference was shown in the customers' understanding of health information received from materials and 54.7% of female and 39.8% of male respondents answered that they have received sufficient information. One of every five respondents of rural areas and one of every two respondents of Ulaanbaatar evaluated pictures, illustrations and color collages of print media as "suitable and excellent". In addition, 69.1% and 36% of total respondents of Ulaanbaatar and rural areas considered grammar, spelling and composition of information included in the print media as "well-written and well-prepared", respectively. As for the possibility of following and implementing health tips provided in the print media about NCDs, 48.3% of female respondents evaluated as "excellent", 30.6% as "satisfactory" while 38.9% of male respondents evaluated as "excellent" and 34% as "satisfactory". This shows health tips are being processed that is closer to life and feasible. Regarding to sources of information that BHUs used to prepare print media, 21% of them was self-prepared by doctors and medical specialists, 50.8% was prepared by National Center for Public Health, the Ministry of Health and Districts' Health Centers, and 75.4% was prepared by pharmaceutical companies.

Conclusions:

1. Printed materials prepared by BHUs can reach the targeted population at a certain degree and attract their attention. For instance, 73.6% of customers' rating was above average. 92% of doctors and medical specialists' rating was above average and this shows BHUs should include independent evaluators' opinion, especially the targeted population, when preparing materials and implement marketing strategy.
2. It is important to publish materials after carefully reviewing not only design but also grammar, spelling and composition of text of print media. This was more apparent in the rural print media. 30.9% and 64% of print media of Ulaanbaatar and rural areas were published with numerous errors, respectively.
3. The information and comprehensibility of advice and tips included in the print media is relatively good. However, there was gender difference in the understanding health information and as for men, the lack of understanding was noticeable. Therefore, there is a need to segment the targeted population for health information and communication activities and prepare information.
4. Print media for locals that prepared by BHUs on their own is relatively low and majority of BHUs use print media prepared by pharmaceutical companies, the Ministry of Health, National Center for Public Health and Districts Health Center.